



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

“ЗАЛУУ ИНЖЕНЕР КЛУБ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Зорилго: Монголын Эмнэлгийн инженерүүдийн нийгэмлэгийн дэргэдэх “Залуу инженер клуб” нь Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлээр суралцаж буй оюутан залуусыг нэгтгэн, онолын мэдлэгээ практиктай уялдуулж, дадлага туршлага хуримтлуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үндсэн үйл ажиллагаа:

Жил бүр эмнэлгийн техник технологийн үзэсгэлэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн сургалт, чуулган болон спортын гурван төрөлт тэмцээнийг зохион байгуулдаг. Үүний үр дүнд өндөр ур чадвартай инженерүүдийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх залуу боловсон хүчин болгон бэлтгэж байна. Мөн судалгаа, шинжилгээний гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг.

Клубийн гишүүнчлэл:

Клубийн гишүүд нь ЭХИС-ийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын мэргэжлийн бакалавр, магистрын оюутнууд, байдаг бөгөөд одоогийн байдлаар 170 гаруй гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Клубийн зохион байгуулдаг арга хэмжээнүүд:

- Клубийн нэрэмжит танилцах аялал
- Эрдэм шинжилгээний хурал
- Эрүүл мэндийн технологийн үзэсгэлэн
- Урлаг спортын арга хэмжээнүүд
- “Шинэ үеийн инженерүүд манлайлагчдын” лекц
- Сайн үйлсийн аян гэм мэт олон арга хэмжээг зохион байгуулдаг болно.

Холбоо барих:

Хаяг: ШУТИС Эрчим хүчний сургууль Хичээлийн II Байр 416 тоот

Зөвлөх багш: М.Бумбат-88969790

Instagram хаяг: yeclub_fam

Facebook хаяг: Залуу инжежер клуб


Тэргүүн: С.Насанбуян

Түүхэн замнал: Эрчим хүчний инженерчлэлийн сургуулийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлийн багш, Док, дэд профессор Д.Пүрэвдаш, дэд профессор Б.Энхжаргал багш нарын санаачилгаар 2008 онд “Залуу инженер” клубийг байгуулсан.

Клубийн тэргүүнээр Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлийн ангийн дарга У.Батсүх сонгогдож Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер мэргэжлийн 2008 оны элсэлтийн оюутнуудыг гишүүнчлэлээр багтаан анх эхэлсэн.

Өнөөг хүртэл 29 удаагийн элсэлтээр 300 бакалавр, 60 гаруй магистрын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэж төгсгөсөн байна.

Үе үеийн клубийн тэргүүнүүд



У. Батсүх

2008 онд Эмнэлгийн тоног төхөөрөмжийн Залуу инженер клубийг Үүсгэн байгуулж 2010 он хүртэл тэргүүнээр ажиллаж байсан.

2006-2010 онд ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

2012 онд Ходоодны Уян дурангийн ариутгалыг оновчилж, сайжруулах нь сэдвээр Магистрын зэрэг хамгаалсан.

2010-2015 оны хооронд эмнэлгийн тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэгч Эйч Энд Эйч ХХК ийн ЭХО, Уян дурангийн инженерээр ажилласан.

2015 оноос Сүкэ Холдинг ХХК ийг үүсгэн байгуулж Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Сүкэ холдинг ХХК нь Монголын 300 гаруй Шүд, Чих, хамар хоолойн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлж, сургалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна.



Н.Буянбадрах

2010-2011 онд Залуу инженер клубийн тэргүүн байсан.

2009-2013 онд ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

2013-2016 онд Н&Н ХХК-ийн инженер, албаны даргаар ажиллаж байсан.

2017 онд Мед буян ХХК үүсгэн байгуулж одоог хүртэл захирлаар ажиллаж байна.



О.Ялалт

2011-2012 онд Залуу инженер клубийн тэргүүн байсан.

2015 онд ШУТИС- Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтын инженерийн Магистр зэрэгтэй төгссөн.

2012-2021 онд АШУИС-ийн сувилахуйн сургуульд багшаар ажиллаж байсан.

2021 оноос одоог хүртэл ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” мэргэжлийн багшаар ажиллаж байна.



О.Бат-Эрдэнэ

2013-2015 онд Залуу инженер клубийн тэргүүн байсан.
2010-2015 онд ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



Э. Шарав-Эрдэнэ

2016-2017 онд Залуу инженер клубийн тэргүүн байсан.
2012-2020 онд ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

Суралцаж байх хугацаанд Golden med ХХК- д ажиллаж байсан.

Одоогоор япон улсад ажиллаж амьдарч байгаа.



Х. Далайцэрэн

2017-2020 онд Залуу инженер клубийн тэргүүн
2016-2020 онд ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

2020 онд Интерфарм импорт-д ажиллаж байсан.

2021-2023 онд Эх нярай эмэгтэйчүүд үндэсний төв 2 ажиллаж байсан.

2024 оноос Их итгэл төгс ХХК-д ажиллаж байгаа



Б. Насанжаргал

2021-2022 онд Залуу инженер клубийн тэргүүн
2018-2022 онд ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтын инженер” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

2022 оны 2 сараас Улсын нэгдүгээр төв эмнэлэгт ажиллаж байсан.



У. Мадина

2022-2023 онд Залуу инженер клубийн тэргүүн
2020-2024 онд ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтын инженер” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

2024 оноос эхлэн Улсын нэгдүгээр төв эмнэлэгт ажиллаж байна.



С. Энхлэн

2023-2024 онд Залуу инженер клубийн тэргүүн байсан.
2021 оноос ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтын инженер” мэргэжлээр суралцаж байгаа.



Б.Мөнгөнчимэг

2024-2025 онд Залуу инженер клубийн тэргүүн байсан.
2022 оноос ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтын инженер” мэргэжлээр суралцаж байна.



С.Насанбуян

2025 оноос эхлэн Залуу инженер клубийн тэргүүн хийж байгаа.
2023 оноос ЭХИС-ийн “Эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглалтын инженер” мэргэжлээр суралцаж байна

Клубийн онцлох үйл ажиллагаа, амжилтууд

Залуу инженер клубийн тэргүүн У.Батсүх болон анхны удирдах зөвлөлийн гишүүд 2008 оныхоо ажлын төлөвлөгөөг гаргаж түүндээ хүрэхийн тулд долоо хоног бүр үйл ажиллагаа зохион байгуулдаг байсан. Ийнхүү тогтмол үйл ажиллагаа явуулсны эцэст тухайн жилдээ ШУТИС-ийн хамгийн идэвхтэй “ШИЛДЭГ КЛУБ”-ээр шалгарч байсан түүхтэй.



1. “Мэргэжлийн танилцах аялал”



2. “ЭМНЭЛГИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ИРЭЭДҮЙ” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, ажил олгогчдын өдөрлөгийг хамтран зохион байгуулсан.



Эрдэм шинжилгээний хурал болон Ажил олгогчдын өдөрлөг



Эрдэм шинжилгээний хурал

3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч болон багш, оюутнуудын дунд жил бүр "СПОРТЫН 3 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН"-ийг уламжлал болгон зохион байгуулдаг.



Спортын 3 төрөлт тэмцээн



Сагсний тэмцээний шагналт байрууд (залуу инженер клубийн оюутнууд)

4. Монголын Эмнэлгийн Инженерчлэлийн Нийгэмлэг” -ээс зохион байгуулж буй **МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЗЭСГЭЛЭН-2025** олон улсын үзэсгэлэн, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрх зүйн орчин болон аюулгүй байдал сэдэвт сургалтанд амжилттай оролцлоо.

